

### Буудайн навчны хүрэн зэв

Өвчин үүсгэгч: *Puccinia triticina* Erikss.1899

#### Өвчний шинж тэмдэг:

✚ Навч, хааяа навчны углуурга, цөөн тохиолдолд ишин дээр ихэвчлэн навчны дээд талын гадаргууд энэ тэнд заримдаа цагираг байдлаар зэвэн-хүрэн өнгийн төвгөрүүд үүснэ.


✚ Ургалтын сүүл үед төвгөрүүд аажмаар хар өнгөтэй болно. Ургамал их хэмжээгээр өвчилсөн үед төвгөр навчны илтсийг бүхэлд нь бүрхэж, навч хуйлран амархан хатдаг.



Хүрэн зэвээр өвчилсөн  
буудайн навч


#### Ургамал ургалтын хугацаанд өвчин үүсгэгч мөөгөнцөр тархах арга

зам: Салхи, ус /бороо, усалгааны ус/, шавьж, амьтан, хүнээр дамжин тархаж болно.



*Puccinia triticina* мөөгөнцөрийн  
буудайн навчин дээр үүсгэсэн  
спор

Хүрэн зэвийг үүсгэгч *Puccinia triticina* мөөгөнцөрийн хөгжлийн зарим шат буржгар (*Thalictrum* sp) дээр явагддаг бөгөөд түүнийг зэвний мөөгөнцөрийн “завсрын эзэн” хэмээн нэрлэнэ.



Хүрэн зэвээр өвчилсөн Буржгар  
(*Thalictrum* sp)-ын навч

**Хүрэн зэв өвчний халдварын голомт:** өвчилсөн ургамлын үлдэгдэл, хөрс, завсрын эзэн ургамал болох буржгар, халдвартай үр

## Буудайн ишний зэв

Өвчин үүсгэгч: *Puccinia graminis* f. sp. *tritici* Pgt

### Өвчний шинж тэмдэг:

Иш, навчны углуурга заримдаа түрүү, түрүүний хайрсан дээр эпидермисийн доороос түрэн гарсан зэвэн улаан хүрэн, хар хүрэн өнгийн төвгөрүүд үүснэ. Эдгээр төвгөрүүд хоорондоо нийлж шугаман зураас үүсгэдэг учраас заримдаа “шугаман зэв” хэмээн нэрлэдэг.



Ишний зэвээр өвчилсөн буудай

*Puccinia graminis* f. sp. *tritici* Pgt мөөгөнцөрийн буудайн ишин дээр үүсгэсэн спор



**Өвчний голомт:** Ишний зэвийг үүсгэгч мөөгөнцөр өвчилсөн ургамлын үлдэгдэлд өвөлжинө.

Өвчин үүсгэгч *Puccinia graminis* f. sp. *tritici* Pgt мөөгөнцөрийн хөгжлийн зарим шат тошлог (*Berberis* sp) дээр явагддаг бөгөөд түүнийг завсрын эзэн хэмээн нэрлэнэ.



Ишний зэвээр өвчилсөн тошлог (*Berberis* sp)



*Puccinia graminis* f. sp. *tritici* Pgt мөөгөнцөрийн тошлог (*Berberis* sp) дээрх хөгжлийн шат

## Буудайн зэв өвчинтэй тэмцэх аргын менежмент:

### Агротехникийн арга:

- Өвчинд тэсвэртэй сорт сонгон тариалах;
- Үрийг ангилан ялгаж, сайн чанарын үрээр тариалалт хийх;
- Таримлын өвчин тэсвэрлэлтийг сайжруулахын тулд кали, фосфорын бордоог зохих тунгаар хэрэглэх;
- Ургамлын үлдэгдэл болон гуурсыг хавах нь талбай дахь өвчин үүсгэгчийн голомтыг багасгана;
- Талбай дахь болон талбайн захын хог ургамал ялангуяа мөлхөө хиаг болон буржгар зэрэг өвчин үүсгэгчийн завсрын эзэн ургамлыг устгах;
- Ээлжлэн тариалах системийг мөрдөх (сэлгээнд буурцагт ургамал, хошуу будаа, рапс, наранцэцэг г.м таримлыг тариалах);

### Химийн арга:

- Өвчин илэрсэн тохиолдолд Колосаль, КЭ (0.5-1.0 л/га), Колосаль Про КМЭ (0.3-0.6 л/га), Диниконазол 12.5% г.м фунгицидийн аль нэгээр шүршиж, өвчний тархалтыг хязгаарлах арга хэмжээ авах хэрэгтэй.

### Хорио цээрийн арга:

- Халдваргүй үрийг тариалалтанд ашиглах;
- Зэв өвчин тархсан талбайд хэрэглэсэн техник хэрэгслийг цэвэрлэж, ариутгаж ашиглах



Зэв өвчин тархсан  
талбайд техник явах  
үеэр халдвар  
агаараар тархаж буй  
байдал

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

Итгэл Ц, Бямбажав Б “Фитопатологийн дадлагын сурах бичиг” УБ,  
1997

Дэжидмаа Т “Үр тарианы үргамлын өвчин” УБ, 2009

George N. Agrios “Plant pathology” Fourth edition, 1997

<https://www.google.com/search?q=puccinia+graminis++&tbn=isch&ved=2ahUKEwi7n8CHlYfwAhVLb5OKHTZXCEEQ2->

cCegQIABAA&oq=puccinia+graminis++&gs\_lcp=CgNpbWcQAzICCAAyAggAMgIADICCAAyAggAMgIADICCAAyAggAMgIADICCAABQ44IDWLuPA2D0mwNoAHAAeACAAbYBiAG9CpIBBDEuMTGYAQCGaAQGqAQtd3Mtd2l6LWltZ8ABAQ&scIient=i mg&ei=d9F7Y9PuHCMve0QS2rqGIBA&bih=568&biw=1349&rlz=1C1CHBD\_enMN818MN818&hl=en

МТҮХолбооны ажлын албанаас эмхэтгэн  
бэлтгэв. 2021 он.

404 тоом, Unity Center, Оюутны гудамж 44,  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот 14191, Монгол Улс  
office@nationalfarmers.mn Умач:7511-7500